



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/38


Өлгий

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах ажилтнуудыг хамруулан шуурхай зөвлөгөөнийг энэхүү захирамжийг жишиг болгон тогтмол зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамжаар батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг зөвлөгөөнд оролцогч удирдах ажилтнуудад, журмын хувийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ө.Тиянах/-т тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/629 дугаартай захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Е.ЗАНГАР

8324020128